



Living the LOTUS

Buddhism in Everyday Life

«Чухал зүйлийг дамжуулцгаая»

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо

**Чухал нандин зүйл юу болохыг санаж явахын
төлөө арга ухаанаа зарж, “зорилго” тавих нь**

Та бүхэнд шинэ жилийн мэнд хүргэе.

Өнгөрсөн жил дэлхийн 2-р дайн дууссаны 70 жилийн ой байсан. Тиймээс би 2015 оныг «Зэвүүцэхгүй байх» гэсэн үгээр илэрхийлж, хүн хүнээ дорд үзэхгүй байх гэсэн Насад зэвүүцэхгүй бодьсадвагийн зан чанарыг эрхэмлэн, эв нэгдэл, энх тайвны зам мөрөөр алхахыг уриалсан билээ. Япон улс “Хүндэтгэлээр эхэлж, хүндэтгэлээр дуусах” гэсэн эрхэм нандин ёс заншилтай. Улс орныхоо ийм суурь үзэл санааг ухамсарлаж, үргэлж энх тайван улс байхын төлөө хичээх нь гишүүд бидний үүрэг билээ. Гэвч дэлхий дахиныг харахад томоохон хэмжээний алан хядах үйл ажиллагаа, үймээн самуун тасрахгүй байна. Тиймээс эргэн тойрныхоо үйл явдалд үргэлж анхаарал хандуулж, Японы уламжлалт ёс заншил, өөрийн гэсэн онцлогоо ашиглан энх тайван руу чиглэсэн үйл ажиллагаа байнга явуулж байх нь зүйтэй болов уу. Манай байгууллага 1998 оноос хойш «Хүн бүрийн сэтгэлийг сайжруулах Косей Кай» гэсэн нийтийн уриаг дэвшүүлэн хэрэгжүүлж байгааг та бүхэн мэдэж байгаа байх. Мөн 2008 оноос айл бүрт Гол шүтээнийг залах үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлснээр буддизмын суурь ойлголт болох Мөргөлийн гурван эрдэнэ айл бүрт бүрэлдэн тогтсон гэж хэлж болно.

2014 онд Их ариун ордон бүтээн байгуулагдсаны 50 жилийн ой тохиосон. Үүнтэй холбогдуулан Үүсгэн байгуулагчийн Их ариун ордонд шингээсэн хүсэл зорилго юу байсныг бодож үзэхийн зэрэгцээ “51 дэхь жилийг угтах жил” хэмээн зарлаж дахин шинээр эхлэхээ тангарагласан билээ.

Үүсгэн байгуулагчийн хамгийн их хүсэж мөрөөдөж байсан зүйл бол хүн бүр байгууллагынхаа энэ мэтийн түүхэн үйл явдал, юуг зорьж явааг ойлгосны үндсэн дээр бодь сэтгэл (гэгээрлийг зорин бурханы зам мөрөөр явъя гэсэн сэтгэл) болон баярлах сэтгэлээр бурханы зам мөрөөр алхаж, түүнийгээ бусад хүмүүст ч гэсэн дамжуулаасай гэсэн хүсэл байсан болов уу. Тийм ч учраас энэ жил байгууллагын бүтцэд томоохон хэмжээний өөрчлөлт



оруулсан гэж би ойлгож байгаа.

Тэгэхээр би “2016 оны зорилт”-ыг дараах байдлаар тодорхойллоо. Энэ жил ч гэсэн эргэлзээ төвөгтэй асуудалд хөл алдалгүй, чухал нандин зүйл юу болохыг үргэлж санаж явахын төлөө арга ухаанаа зарж, “зорилго” тавьж сургаал номоо дэлгэрүүлцгээе.

Шагжамүни бурхан багшийн хүсэл зорилгыг сайтар ухан ойлгож, цааш нь дамжуулцгаая.

Бурхан багш, Үүсгэн байгуулагч, Их дагагч Мёокоо багштан нарынх шиг энэрэн нигүүлсэх сэтгэл, хүний уг мөн чанар болох гэгээлэг, эелдэг, халуун дулаан сэтгэлийг эрхэмлэн, бодисадвагийн үйл (хүний уг зам мөр)-г үргэлжлүүлэн хэрэгжүүлцгээе.

Би жилийн эхний айлдвартаа 2012 оноос авахуулаад 4 жилийн турш “нэмэлт” хэсэг оруулж байсан боловч энэ жил тэр хэсгийг хаслаа. Яагаад гэвэл нэмэлт хэсэгт бичсэн “Японы зүүн бүс нутгийн их газар хөдлөлт болон бусад олон янзын байгалийн гамшигаар амь насаа алдсан талийгаачдын сүнсийг амирлуулж, хүндэтгэл үзүүлэх”, “хүний хөгжилд хувь нэмэр оруулах”, “өөр өөрсдийнхөө боломжоор бүс нутаг, нийгэм, улс, дэлхий нийтийн сайн сайхны төлөө хувь нэмэр оруулах” гэсэн зорилтуудыг гишүүд та бүхэн хангалттай ойлгосоны дээр эдгээрийг цаашид урт удаан хугацааны турш үргэлжлүүлэн хийх нь ойлгомжтой учраас хассан билээ.

Энэ жилийн хувьд “зорилго тавих”, “Шагжамүни буддагийн хүсэл зорилгыг дамжуулах”, “бодьсадвагийн зам мөрийг хэрэгжүүлэх” гэсэн 3 “Зорилт”-ыг тодорхойллоо.

“Зорилго тавих”-ын тухайд ерөнхийд нь ойрын, дундын, холын гэж хувааж болно. Яг одоо хийх ёстой зүйл нь ойрын зорилго болно. Түүнчлэн амьдралыг хэрхэн туулах вэ гэсэн чухал зорилт байна. Бүр энэ насандаа төдийгүй хойд насандаа ч гэсэн сүнсээ ариусгах гэсэн урт хугацааны, мөнхийн зорилго ч байна. Үүнтэй харьцуулахад “амьдралыг хэрхэн туулах вэ” гэдэг нь дунд хугацааны зорилго гэж хэлж болохоор байна. Хүн хүнээсээ шалтгаалан эхлээд холын зорилгоо тавьчихаад тэндээсээ дундын болон ойрын зорилгоо тодорхойлдог хүн ч байгаа байх. Эсвэл ямар нэг тодорхой зорилгодоо хүрэхийн тулд ойрын, дундын, холын зорилгоо тодорхойлдог хүн ч байж магадгүй. Ямартай ч зорилгоо тодорхойлохдоо чухал нандин зүйл юу болохыг мартахгүй байхын төлөө арга ухаанаа зарах нь чухал юм.

Шагжамүни буддагийн хүсэл зорилго юу байсныг үргэлж бодож, бурханы үйлд шамдацгаая

Мөн энэ жил “Шагжамүни буддагийн хүсэл зорилгыг сайтар ухан ойлгож, цааш нь дамжуулцгаая” гэж би дээр дурьдсан.

Шагжамүни будда нирваанд орохынхоо өмнө шавь нартаа “Өөрөө зул мэт байж, Дармаг зул мэт сэтгэ” хэмээн захиж үлдээсэн байдаг.

Тэрээр хүн болгон биеэ даасан сүсэгтэн болж, утга учиртай амьдралыг туулаасай, жинхэнэ үнэний хуулийг ухамсарлаж, жинхэнэ аз жаргалыг олж аваасай хэмээн хүссэн юм. Гэвч хэсэг бүлэг хүмүүс өөртөө найдахгүй Бурхан багшид найдан, буддын шашин шүтлэг гэдэг хүсэл мөрөөдлийг биелүүлж өгдөг зүйл гэж буруу ойлгож байсныг үгүйсгэхгүй. Угтаа Буддын ухаан нь эсрэгээр “хүсэл их байх тусмаа зовдог юм шүү”, “шунал хүслээ хаяцгаая” хэмээн сургадаг билээ. Тиймээс Шагжамүни буддагийн сургаалыг эргүүлж гуйвуулалгүй, байгаагаар нь хүлээж авах чухал.

Түүнчлэн Шагжамүни буддагийн айлдсан “зовлон” гэдэг нь угтаа



“санаснаар болохгүй зүйл”-ийг хэлдэг ба үүнд 8 зовлон (төрөх, өглөх, өвдөх, үхэх, хайртай хүнээсээ хагацах, дургүй хүнтэйгээ учрах, хүссэнээ авч чадахгүй байх, санаснаар болохгүй байх) байдаг гэсэн байдаг. Гэвч орчин үед өөрт тааламжгүй зүйл, гай гамшиг, саад бэрхшээл зэрэг бүх л зүйлийг “зовлон” хэмээн хүлээн авдаг болж, Шагжамүни буддагийн айлдсан “зовлон” гэдгийн жинхэнэ утга алдагдсан гэж ярьцгааж байна.

Мэдээж хэрэг ямар ч хүн бодит үр ашиг харах нь ойлгомжтой. Аливаа зүйлтэй тулгарахаараа нэг баярлаж нэг сэтгэлээр унах нь ч гэсэн мэдээжийн зүйл. Гэхдээ хүсэл биелэж, зовлон алга болохоор ингээд бүх зүйл сайхан боллоо гээд дуусах биш, харин ч тэр мөчөөс эхлэн бурханы сургаалын жинхэнэ мөн чанарыг ухаарахын төлөө үргэлж Шагжамүни буддагийн хүсэл зорилго юу байсныг бодож, бурханы үйлд шамдах нь зүйтэй. Мөн эргэн тойронд тань байгаа санга төдийгүй уулзан учрах хүн бүхэнд “Өөрөө зул мэт байж, Дармаг зул мэт сэтгэ” хэмээх сургаалыг дамжуулж, номын замд хөглөн оруулах гэсэн нэн чухал үүргийг биелүүлэхийг хүсэж байна.

Шагжамүни буддагийн сургаалын гол цөм нь “Бүх юмс хувирч өөрчлөгддөг” ба “Юу ч ганцаар оршин тогтнодоггүй” гэсэн сургаал билээ. Дхаммапада буюу Номын бадаг сударт “Хүмүүний амийг хүртэх амар зүйл биш, хэзээ нэгэн цагт үхэх жамтай атал амьд байна гэдэг ямар сайхан бэ. Зөв сургаалтай учрах амаргүй атал бурхад ертөнцөд мэндэлнэ гэдэг юутай сайхан бэ” гэсэн хэсэг байдаг. Энэхүү сургаал нь тогтворгүйн хуулиар дамжуулан өөрийн болон бусдын амь нас гэдэг ямар гайхамшигтай, эрхэм нандин бөгөөд амар олддоггүй зүйл болохыг ухаарахын чухлыг сургасан юм.


Харин бид нарны гэрэл, ус, агаар, амьтан, ургамал, эрдэс бодис гэх мэт сансар огторгуйн бүхий л зүйлсийн ачаар амьд яваа гэдэг маань юу ч ганцаар оршин тогтнодоггүй гэдгийг батална. Гар хөдөлж, алхаж, хоол идэж, амьсгалж, ярьж, унтах гээд бид аль хэдийн олон сайхан зүйлийг хүртсэн байна шүү дээ. Үүнийг ухамсарлан ямар ч хүнд хэцүү зүйлтэй тулгарсан “бүгд Бурханы сургаал” хэмээн хүлээн авч, алдаа дутагдлаа эргэцүүлэн бодож, аз жаргалыг эрж олоод талархаж байгаа гишүүд олон байна.

Хорвоо ертөнцөд зөвхөн хүн л талархаж чаддаг амьтан болохоор “баярлалаа” гэж хэлж чадна гэдэг хүний хувьд маш том аз жаргал бөгөөд амьдралын утга учир юм.

Өглөгийн жинхэнэ мөн чанар хүн хүнээ ойлгох сэтгэлээс гарах энгийн үйл хөдлөлд оршино

Мөн бид бүхэн зөвхөн өөрөө л аз жаргалтай болвол болоо гэх биш, хамаг амьтан бүхний аз жаргалын төлөө бодьсатвагийн зам мөрөөр алхаж байгаа билээ. Бодьсатвагийн хамгийн чухал үйл бол 6 барамид сургаалын хамгийн эхний өглөгийн барамид байдаг. Өглөг гэдэг нь энэрэн нигүүлсэх, өрөвдөн хайрлах, өгөх, авснаа мартах гэсэн утгуудтай. Үүнд үндэслэн бид өдөр тутамдаа номын өглөг (бурханы сургаалыг айлдан түгээх), биеийн өглөг (биеэ ашиглан сайн үйл хийх), эдийн өглөг (эд юмсаар өглөг өргөх) зэргийг хийдэг.

Нийгэмд бол өглөг гэхээр эд юмс өгөх гэж ойлгох нь их байх. Гэвч утгаа ээлдэг үйлдэл ч гэсэн өглөг ба ажил, нийгэм, гэр орон гээд өөр өөрсдийн байгаа газраа идэвхи зүтгэлтэй амьдрах нь хүртэл өглөг болно. Бараа түгээгчийн ажлаар жишээ аваад үзвэл, тэр ажил нь тухайн



2016 оны айлдвар

хүний амьдралыг залгуулахаас гадна бараа хүлээж авсан хүнээ ч гэсэн баярлуулдаг шүү дээ. Ингээд бодоод үзэхээр өдөр тутмын амьдрал бүгд өглөгтэй холбоотой гэж хэлэхэд хэлсдэхгүй.

Тиймээс өглөг гэдэг нь хэн нэгэнд ямар нэг зүйлийг өгснөөр бий болдог зүйл гэсэн үг биш угаасаа хүний амьдралын нэгэн хэсэг болон оршдог гэж хэлж болно. Шагжамүни будда ертөнцийн аливаа юмс үзэгдэл хоорондоо олон давхар торон сүлжээгээр холбогдож, харилцан бие биенээсээ хамааралтай оршдог нэгэн бүхэл амь хэмээн айлдсан. Үүнийг Зэн буддизмын их багштан Доогэн “би” ба “чи” нь угтаа нэг бүхэл юм хэмээн тайлбарласан байдаг.

Тиймээс бурханы сургаал дахь өглөгийн жинхэнэ мөн чанар нь бусдын баяр хөөр нь миний баяр хөөр, бусдын гуниг зовлон нь миний гуниг зовлон гэсэн хүн хүнээ ойлгох сэтгэлээс гарсан энгийн үйлдэлд оршдог юм.

Өглөгийг юуны түрүүнд хэрэгжүүлээд үзэх нь чухал. Жишээлбэл, номын өглөгийн хувьд сургаалыг бүрэн ойлгосныхоо дараа хүмүүст дамжуулна гэвэл хугацаа алдах тул анзаарч ойлгосон зүйл, сэтгэл хөдөлсөн зүйлээ чин сэтгэлээсээ дамжуулж байх чухал. Бусдыг баярлуулснаар өөрөө түүнээс хоёр дахин их баяр хөөрийг мэдэрдэг билээ. Мөн ямар ч зүйл дээр эхлээд “гаргах” чухал байдаг. Гарч ороход “гарах” хүний эрх түрүүнд тавигдана. Амьсгалахад ч гэсэн эхлээд амьсгаагаа “гаргах” чухал байдаг. Өглөг ч гэсэн үүнтэй адил санагдаж байна.

Шашныг нэг үгээр илэрхийлэх юм бол “хүн хэрхэн амьдрах ёстой вэ” гэдгийг тодруулдаг зүйл гэж хэлж болно. Гэхдээ “нэг насны амьдрал нь нэг өдрүүдийн нийлбэр” гэдэг шиг, амьдрал ямар байх нь эцсийн дүндээ нэг өдрийг хэрхэн үр бүтээлтэй өнгөрөөхөөс л шалтгаалдаг. Би энэхүү чухал зүйлийг цааш нь дамжуулахын төлөө гишүүд та бүхэнтэй хамтдаа бурханы зам мөрд зүтгэх болно.



Рисшо Косей Кай

